



ГАДААД ХУДАЛДААНЫ САРЫН ТОЙМ*

2020 оны 11 дүгээр сар

Ерөнхий тойм: Энэ оны эхний 11 сарын гүйцэтгэлээр гадаад худалдааны нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 7%-иар буюу 898 сая ам.доллараар буурч 11,742 сая ам.доллар байв. Үүнд экспорт 3%-иар буюу 200 сая ам.доллараар, импорт 12%-иар буюу 697 сая ам.доллараар тус тус буурсан нь нөлөөлөв. Тайлант хугацаанд худалдааны тэнцэл өнгөрсөн оны мөн үеэс 497 сая ам.доллараар өсч 1,969 сая ам.долларын ашигтай гарлаа.

Хүснэгт 1. Гадаад худалдааны гүйцэтгэл /сая ам.доллар/


Төрөл	Ж илээр			Өөрчлөлт				Эхний 11 сар			Өөрчлөлт			
	2017	2018	2019	2018/2017		2019/2018		2018	2019	2020	2019/2018		2020/2019	
				Дүн	Хувь	Дүн	Хувь				Дүн	Хувь	Дүн	Хувь
Эргэлт	10,538	12,887	13,747	2,349	22%	861	7%	11,852	12,639	11,742	787	7%	(898)	-7%
Экспорт	6,201	7,012	7,620	811	13%	608	9%	6,481	7,056	6,855	575	9%	(200)	-3%
Импорт	4,337	5,875	6,128	1537	35%	253	4%	5,372	5,584	4,887	212	4%	(697)	-12%
Тэнцэл	1,863	1,137	1,492	(726)		355	31%	1,109	1,472	1,969	363	33%	497	34%

Валютын төлбөртэй худалдааны тэнцэл** 2020 оны эхний 11 сарын гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үеэс 608 сая ам.доллараар өсч, 2,180 сая ам.долларын ашигтай гарсан байна.

Зураг 1. Валютын төлбөр (ВТ)-тэй худалдаа /3 сарын гулсах дундаж/




Зураг 2. Худалдааны тэнцэл, голлох түнш орнуудаар



Хөрш орнуудтай хийсэн худалдааг авч үзвэл, нийт бараа эргэлтийн 57% буюу 6,739 сая ам.долларын худалдааг БНХАУ-тай, 11% буюу 1,321 сая ам.долларын худалдааг ОХУ-тай хийжээ. ОХУ-тай хийсэн худалдаа өмнөх оны мөн үеэс 17%-иар, харин БНХАУ-тай хийсэн худалдаа 18%-иар буурсан үзүүлэлттэй байна.

Зураг 3. Худалдааны нөхцөлийн индекс /3 сарын гулсах дундаж/



Гадаад худалдааны нөхцөлийн индекс 2020 оны 11 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 25%-иар, өмнөх сараас 2%-иар тус тус өсч 2.051-д хүрлээ. Худалдааны нөхцөлийн индекс өмнөх оны мөн үеэс өсөхөд зэсийн баяжмал, чулуун нүүрс болон алтны экспортын үнэ өссөнөөр тайлбарлагдаж байна. Харин өмнөх сараас өсөхөд зэс болон хэрэглээний барааны импортын үнийн өсөлтөөс голлон шалтгаалжээ.

*Энэхүү тоймыг ГЕГ-ын "Гадаад худалдааны барааны статистик мэдээлэл"-д үндэслэн, дэлхийн улс орнуудын Төв банкны практикт нийцүүлж, судалгаа шинжилгээний ажлын хэрэгцээнд зориулан боловсруулав.

** Нийт худалдааны дүнгээс дахин экспорт/импорт, боловсруулах бараа, бараа солилцоо, хөрөнгө оруулалтаар нийлүүлсэн бараа, гадаадын зээлийн хөрөнгөөр нийлүүлсэн бараа болон бусад барааг хассан дүн болно.

Экспорт: 2020 оны эхний 11 сарын гүйцэтгэл өнгөрсөн оны мөн үеэс 3%-иар буюу 200 сая ам.доллараар буурав. Үүнд мал аж ахуй болон аж үйлдвэрийн бүтээгдэхүүний экспорт буурсан нь нийт экспортыг 3 нэгж хувиар бууруулах чиглэлд нөлөөлөв. Уул уурхайн түүхий эдийн нийт экспортод эзлэх хувь өнгөрсөн оны мөн үеэс 4 нэгж хувиар өссөн бол мал аж ахуйн бүтээгдэхүүний экспортын эзлэх хувь 2 нэгж хувиар буурсан байна.

Хүснэгт 2. Экспортын гүйцэтгэл /сая ам.доллар/

Төрөл	2018			2019			2020			Δ (2019/2018)			Δ (2020/2019)			
	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Дүн	Өсөлт	%²	Дүн	Өсөлт	%²	
1. Уул уурхай		5,729	88%		6,282	89%		6,377	93%		553	10%	9%	94	2%	1%
1.1 Зэсийн хүдэр, баяжмал	1,311	1,824	28%	1,293	1,671	24%	1,256	1,528	22%	(153)	-8%	-2%	(143)	-9%	-2%	
1.2 Чулуун нүүрс	33,355	2,617	40%	34,784	2,944	42%	26,998	2,003	29%	327	12%	5%	(941)	-32%	-13%	
1.3 Боловсруулаагүй нефть	5,669	367	6%	5,998	335	5%	3,563	128	2%	(32)	-9%	0%	(207)	-62%	-3%	
1.4 Төмрийн хүдэр, баяжмал	6,743	308	5%	7,580	519	7%	7,618	586	9%	212	69%	3%	67	13%	1%	
1.5 Мөнгөжөөгүй алт /кг/	3,432	144	2%	7,464	344	5%	27,704	1,625	24%	200	138%	3%	1,280	372%	18%	
1.6 Цайрын хүдэр, баяжмал	114	184	3%	125	175	2%	123	152	2%	(8)	-5%	0%	(23)	-13%	0%	
1.7 Жонш, лейцит, нефелинт	492	166	3%	631	187	3%	605	140	2%	21	13%	0%	(47)	-25%	-1%	
1.8 Молибдений хүдэр, баяжмал	5	45	1%	5	45	1%	6	36	1%	1	2%	0%	(9)	-20%	0%	
1.9 Гянт болдын хүдэр, баяжмал	1	7	0%	1	6	0%	0	1	0%	(1)	-13%	0%	(6)	-89%	0%	
1.10 Мөнгө /тонн/	0	1	0%	0	-	0%	196,020	114	2%	(1)	0%	0%	114	0%	2%	
1.11 Бусад	484	67	1%	136	55	1%	94	63	1%	(12)	-18%	0%	8	15%	0%	
2. Мал аж, ахуй	366	450	7%	285	447	6%	186	275	4%	(3)	-1%	0%	(172)	-38%	-2%	
2.1 Амьд мал, малын мах	34	73	1%	29	61	1%	19	37	1%	(11)	-16%	0%	(24)	-39%	0%	
2.2 Арьс, шир	305	15	0%	230	13	0%	149	7	0%	(2)	-15%	0%	(6)	-47%	0%	
2.3 Малын өлөг гэдэс	1	7	0%	0	7	0%	1	8	0%	0	3%	0%	1	12%	0%	
2.4 Ноолуур	9	326	5%	8	338	5%	8	209	3%	12	4%	0%	(129)	-38%	-2%	
2.5 Ноос, бусад үс, хялгас	14	26	0%	15	25	0%	9	12	0%	(1)	-3%	0%	(13)	-53%	0%	
2.6 Бусад	4	3	0%	3	2	0%	0	1	0%	(1)	-26%	0%	(1)	-50%	0%	
3. Газар тариалан	45	12	0%	48	11	0%	39	11	0%	(0)	-3%	0%	(0)	-2%	0%	
4. Аж үйлдвэрлэл	203	289	4%	356	314	4%	194	191	3%	25	9%	0%	(123)	-39%	-2%	
4.1 Хүнс	29	78	1%	17	43	1%	23	61	1%	(34)	-44%	-1%	18	4%	0%	
4.2 Ноолууран эдлэл	1	33	1%	1	42	1%	1	31	0%	9	27%	0%	(12)	-18%	0%	
4.3 Бусад хувцас, гутал, эдлэл	3	23	0%	4	18	0%	5	15	0%	(5)	-21%	0%	(4)	-29%	0%	
4.4 Уул уурхай	50	98	2%	155	104	1%	17	44	1%	6	6%	0%	(60)	-58%	-1%	
4.5 Чахилгаан, электрон бараа	0	3	0%	0	1	0%	0	1	0%	(2)	-74%	0%	(0)	-14%	0%	
4.6 Машин механик, тоног төхөөрөмж, эд ан	3	49	1%	2	99	1%	2	36	1%	50	103%	1%	(63)	-64%	-1%	
4.7 Бусад	118	4	0%	178	7	0%	147	4	0%	2	46%	0%	(2)	-32%	0%	
5. Бусад	1	1	0%	1	1	0%	0	1	0%	(0)	-22%	0%	0	15%	0%	
Нийт дүн		6,481		7,056			6,855			575	9%		(200)	-3%		

%² - Нийт өсөлтөд оруулсан хувь нэмэр (contribution to growth)

Хүснэгт 3. Экспортын өөрчлөлт, 2020 оны эхний 11 сар

Төрөл	Тоо хэмжээний өөрчлөлт		Үнийн өөрчлөлт		Нийт өөрчлөлт	
	Тоо хэмжээний өөрчлөлт	%	Үнийн өөрчлөлт	%	Нийт өөрчлөлт	%
1. Уул уурхай	555		(461)		94	2%
1.1 Зэсийн хүдэр, баяжмал	(44)	31%	(98)	69%	(143)	-9%
1.2 Чулуун нүүрс	(578)	61%	(363)	39%	(941)	-32%
1.3 Боловсруулаагүй нефть	(88)	42%	(119)	58%	(207)	-62%
1.4 Төмрийн хүдэр, баяжмал	3	4%	94	96%	67	13%
1.5 Мөнгөжөөгүй алт /кг/	1,187	93%	63	7%	1,280	372%
1.6 Цайрын хүдэр, баяжмал	(1)	7%	(21)	93%	(23)	-13%
1.7 Жонш, лейцит, нефелинт	(6)	13%	(41)	87%	(47)	-25%
1.8 Молибдений хүдэр, баяжмал	3	-37%	(12)	137%	(9)	-20%
1.11 Бусад	(28)	-340%	36	440%	8	15%
2. Мал аж, ахуй	(30)	17%	(142)	83%	(172)	-38%
2.1 Амьд мал, малын мах	(18)	76%	(6)	24%	(24)	-39%
2.2 Арьс, шир	(4)	62%	(2)	38%	(6)	-47%
2.4 Ноолуур	9	-7%	(137)	107%	(129)	-38%
3. Газар тариалан	(2)	1258%	2	-1158%	(0)	-2%
4. Аж үйлдвэрлэл	(338)	275%	215	-175%	(123)	-39%
5. Бусад	(0)	-249%	0	8%	0	15%
Нийт дүн	185		(386)		(200)	-3%

* Ижил зориулалттай боловч харилцан адилгүй шинж чанартай бараа бүтээгдэхүүнүүд 1 ангилалд багтдаг тул дээрх тооцоолол нь зөвхөн ерөнхий хандлагыг харуулах тойм тооцоолол болохыг анхаарна уу.

Зураг 4. Дэлхийн зах зээл дээрх уул уурхайн түүхий эдийн үнэ



2020 оны эхний 11 сарын гүйцэтгэлийг өнгөрсөн оны мөн үеийн гүйцэтгэлтэй харьцуулж, нийт 200 сая ам.долларын бууралтыг харвал:

1/ Уул уурхайн бүтээгдэхүүний экспорт тоо хэмжээний өөрчлөлтөөс шалтгаалж 555 сая ам.доллараар өсч, үнийн өөрчлөлтөөс шалтгаалж 461 сая ам.доллараар буурсан.

Тодруулбал: чулуун нүүрс, зэсийн баяжмалын экспортын биет хэмжээ болон үнийн өөрчлөлтөөс шалтгаалж 1,080 сая ам.доллараар буурсан бол алтны экспорт тоо хэмжээний болон үнийн өсөлтөөс хамаарч 1,280 сая ам.доллараар өсчээ.

2/ Мал аж ахуйн бүтээгдэхүүний экспортын хувьд биет хэмжээний бууралтаас шалтгаалж 30 сая ам.доллараар, үнийн өөрчлөлтөөс шалтгаалан 142 сая ам.доллараар тус тус буурав.

Дэлхийн зах зээл дээрх 1 унц алтны дундаж үнэ 2020 оны 11 дүгээр сард, 1,866 ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 27%-иар өссөн бол өмнөх сараас 2%-иар буурав. “А” зэрэглэлийн цэвэршүүлсэн зэс болон төмрийн хүдрийн дундаж үнэ тайлант сард харгалзан 7,069; 124 ам.долларт хүрч өмнөх оны мөн үетэй харьцуулахад зэс 21%-иар, төмрийн хүдэр 46%-иар, харин өмнөх сартай харьцуулбал зэс 5%-иар, төмрийн хүдэр 4%-иар тус тус өсчээ.

Чулуун нүүрсний экспортын хилийн үнэ 11 дүгээр сард 73 ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 8%-иар буурсан бол өмнөх сараас 0.3%-иар өссөн үзүүлэлттэй байна.

Импорт 2020 оны эхний 11 сарын гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 12%-иар буюу 697 сая ам.доллараар буурав. Импортын 12 нэгж хувийн бууралтыг ерөнхий ангиллаар авч үзвэл хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний бууралт 5 нэгж хувийг, нефтийн бүтээгдэхүүний бууралт 5 нэгж хувийг, хэрэглээний бүтээгдэхүүний бууралт 2 нэгж хувийг тус тус бүрдүүлж байна.

Хүснэгт 4. Импортын гүйцэтгэл /сая ам.доллар/

Төрөл	2018			2019			2020			Δ (2019/2018)			Δ (2020/2019)			
	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Дүн	Өсөлт	% ²	Дүн	Өсөлт	% ²	
Хэрэглээний бүтээгдэхүүн		1,491	28%		1,502	27%		1,404	29%		11	1%	0%	(98)	-7%	-2%
Түргэн эдлэгтэй	888	784	15%	825	777	14%	889	808	17%	(6)	-1%	0%	31	4%	1%	
Хүнс	423	542	10%	392	546	10%	414	563	12%	4	1%	0%	17	3%	0%	
Эм, гүриа	3	107	2%	3	98	2%	3	109	2%	(9)	-9%	0%	12	12%	0%	
Бусад түргэн эдлэгтэй бараа	463	135	3%	430	134	2%	473	135	3%	(1)	-1%	0%	2	1%	0%	
Удаан эдлэгтэй	214	707	13%	282	724	13%	266	596	12%	18	2%	0%	(129)	-18%	-2%	
Гулал, хуцас, цүнх	57	69	1%	59	63	1%	83	67	1%	(6)	-9%	0%	4	6%	0%	
Гэр хуйн цах хэрэгсэл ба твигла	84	107	2%	147	98	2%	103	96	2%	(8)	-8%	0%	(2)	-2%	0%	
Авто машин, түүний сэлбэг хэрэгсэл	2	455	8%	2	485	9%	1	350	7%	30	7%	1%	(134)	-28%	-2%	
Бусад удаан эдлэгтэй бараа	71	77	1%	75	79	1%	79	83	2%	2	3%	0%	4	5%	0%	
Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн	1,356	2,205	41%	1,190	2,416	43%	1,368	2,143	44%	211	10%	4%	(273)	-11%	-5%	
Машин, механик тоног төхөөрөмж, эд анги	29	1,385	26%	26	1,613	29%	34	1,313	27%	229	17%	4%	(301)	-19%	-5%	
Суудлаас бусад төврийн хэрэгсэл, эд анги	1	406	8%	2	532	10%	8	464	10%	125	3%	2%	(67)	-13%	-1%	
Машин механик, гяног төхөөрөмж, эд анги	28	978	19%	24	1,082	19%	26	848	17%	103	11%	2%	(234)	-22%	-4%	
Барилгын материал	739	615	11%	926	614	11%	1,220	579	12%	(0)	0%	0%	(36)	-6%	-1%	
Хөрөнгө оруулалтын бусад бараа	42	206	4%	40	188	3%	122	251	5%	(18)	-9%	0%	63	34%	1%	
Аж үйлдвэрлэлийн орц	1,431	664	12%	1,661	612	11%	1,692	583	12%	(62)	-8%	-1%	(29)	-5%	-1%	
Хүнсний орц	278	77	1%	48	22	0%	154	43	1%	(55)	-7%	-1%	20	90%	0%	
Химийн бүтээгдэхүүн	190	112	2%	206	110	2%	183	101	2%	(2)	-2%	0%	(9)	-8%	0%	
Даавуу, утас, арьс, савхин эдлэл	75	28	1%	74	26	0%	67	22	0%	(3)	-10%	0%	(4)	-14%	0%	
Цахилгаан эрчим хүч	1	130	2%	2	130	2%	110	128	3%	0	0%	0%	(3)	-2%	0%	
Металлын хүдэр, баяж мал болон хаягдал	1	1	0%	1	1	0%	1	1	0%	0	24%	0%	0	9%	0%	
Бусад аж үйлдвэрлэлийн зориулалтай	811	315	6%	860	322	6%	854	288	6%	7	2%	0%	(34)	-11%	-1%	
Нефтийн бүтээгдэхүүн	1,431	1,006	19%	1,661	1,049	19%	1,692	743	15%	43	4%	1%	(306)	-29%	-5%	
Дизель түлш	764	515	10%	989	612	11%	917	386	8%	98	19%	2%	(227)	-37%	-4%	
АИ-92, АИ-95	333	238	4%	413	250	4%	492	207	4%	12	5%	0%	(43)	-17%	-1%	
А-80 болон бусад	335	254	5%	259	187	3%	283	151	3%	(67)	-26%	-1%	(37)	-20%	-1%	
Бусад	14	6	0%	5	5	0%	231	14	0%	(1)	-16%	0%	9	169%	0%	
Нийт дүн		5,372		5,584			4,887			212	4%		(697)	-12%		

² - Нийт өсөлтөд оруулсан хувь нэмэр (contribution to growth)

Хүснэгт 5. Импортын өөрчлөлт, 2020 он эхний 11 сар

Төрөл*	Тоо хэмжээний өөрчлөлт		Үнийн өөрчлөлт		Нийт өөрчлөлт	
	Тоо	%	Тоо	%	Тоо	%
Хэрэглээний бүтээгдэхүүн	16	-16%	(114)	116%	(98)	-7%
Хөрөнгө оруулалтын бүтээгдэх	430	-158%	(703)	258%	(273)	-11%
Аж үйлдвэрлэлийн орц	139		(168)		(29)	-5%
Нефтийн бүтээгдэхүүн	16	-5%	(322)	105%	(306)	-29%
Дизель түлш	(30)	13%	(196)	87%	(227)	-37%
АИ-92, АИ-95	33	-77%	(77)	177%	(43)	-17%
А-80 болон бусад	13	-35%	(49)	135%	(37)	-20%
Бусад	14		(5)		9	169%
Нийт дүн	614	-88%	(1,311)	188%	(697)	-12%

* Ижил зориулалттай боловч харилцан адилгүй шинж чанартай бараа бүтээгдэхүүнүүд 1 ангилалд багтдаг тул дээрх тооцоолол нь зөвхөн ерөнхий хандлагыг харуулах тойм тооцоолол болохыг анхаарна уу.

Зураг 5. Импортын бүтээгдэхүүний жилийн өсөлт /3 сарын гулсах дундаж/



2020 оны эхний 11 сарын гүйцэтгэлийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал, нийт импорт 697 сая ам.доллараар буурсан. Үүнд:

- Машин, хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн буюу механик тоног төхөөрөмжийн импорт 273 сая ам.доллараар,

- Дизель түлшний хэрэглээнээс хамаарч нефтийн бүтээгдэхүүний импорт 306 сая ам.доллараар,

- Хэрэглээний бүтээгдэхүүний импорт 98 сая ам.доллараар,

- Аж үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний импорт 29 сая ам.доллараар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Нефтийн бүтээгдэхүүний импортын хилийн үнэ 2020 оны 11 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 35%-иар, өмнөх сараас 3%-иар тус тус буурч, тонн тутамд 423 ам.долларт хүрэв.